



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/61

Дуурсах

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.2 дах заалтууд, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Эрүүл мэндийн сайдын А/780 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд зохион байгуулах бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар, хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтыг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ахмад настан, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Амарсайнуу)-д үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаанд зарцуулах 904.000 (Есөн зуун дөрвөн мянган төгрөг)-ийг хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын оны
..... дугаар сарын ны өдрийн
А/64... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УДИРДАМЖ

**“Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд зохион байгуулах
бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын
сургалт зохион байгуулах тухай**

Нэг. Үндэслэл

Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох үндэсний 4-р судалгаанд Монгол улсын 15-69 насны хүн амын 21.9 хувь нь хөдөлгөөний хомсдолтой, суугаа идэвхгүй байдалд хоногт дундажаар 3-4 цагийг зарцуулдаг, 52.4 хувь нь ажлын байрандаа, 48.2 хувь нь амралт чөлөөт цагаараа эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй, 49.4 хувь нь илүүдэл жин, таргалалттай байна. Илүүдэл жин, таргалалтын тархалт хүн амын насны бүлэг ахих тутам нэмэгдэж бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ эрэгтэйчүүдэд 87.3 см, эмэгтэйчүүдэд 85.7 см байна. Бүсэлхийн тойргийн эрсдэлийн үнэлгээгээр нийт хүн амын 53 хувь, эрэгтэйчүүдийн 41.9 хувь, эмэгтэйчүүдийн 64.2 хувь нь төвийн таргалалттай, хот суурин газрын хүн амд төвийн таргалалт хөдөө орон нутгийнхаас их, нийт хүн амын 25.9 хувь нь биед агуулагдах өөхөн эдийн хэмжээ маш их байна.

Иймээс эрүүл мэндийн салбарын нийт ажилтан, албан хаагчдыг бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил судалгаанд хамруулж, дасгал хөдөлгөөнийг нийтийн үйл хэрэг болгон, сурталчлан таниулах, хөдөлгөөнөөр хичээллэх идэвхийг нэмэгдүүлэн, дархлааг дэмжих нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Хоёр. Зорилго

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх хүн амыг бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, дасгал хөдөлгөөнд хамруулан эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургаж, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужлыг бий болгон иргэдийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэх сонирхолыг өрнүүлж, биеийн тамир спортоор хичээлэгсдийн тоог нэмэгдүүлэх, биеийн тамир, спорт, дасгал хөдөлгөөнийг нийтийн үйл хэрэг болгоход оршино.

Гурав. Зорилт

1. Эрүүл мэндийн салбарын биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан ажилтнуудыг сорил авах мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх.
2. Хөдөлгөөний ач холбогдолыг таниулснаар, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх идэвх санаачилгыг бий болгох.

Дөрөв. Хамрах хүрээ

Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн чийрэгжүүлэлт хариуцсан ажилтнууд

Тав. Сургалт зохион байгуулагдах хугацаа

2022 оны 09 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд Эрүүл мэндийн газрын сургалтын зааланд 09:00 цагт

Зургаа. Сорил явагдах хугацаа

2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 09 дүгээр сарын 16-ны хооронд зохион байгуулна.

Долоо. Үр дүн

- Эрүүл мэндийн анхан шатны нэгжүүдэд бие бялдрын түвшин тогтоох сорил авах ажилтан бэлтгэгдсэн байна.
- Хөдөлгөөний ач холбогдолыг таниулснаар, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, сурталчилах идэвх санаачилга нэмэгдэнэ.

Холбоо барих утас: 95119489

ХЯНАСАН:


НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН

ДАРГА



Д.БАЛЖМАА

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН  Ц.АМАРСАЙНУУ

Эрүүл мэндийн газрын даргын оны
 дугаар сарын ны өдрийн
 А.Б.А дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд зохион байгуулах
 бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын
 сургалтад зарцуулагдах зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Давтамж	Нэгжийн үнэ	Мөнгөн дүн
1	2	3	4	5	6	7
1	Цайны зардал	Хүн/өдөр	26	4	6000	624.000
2	Сургалтын бичиг хэрэг	хүн	26	1	5.000	130.000
3	Багшийн хөлс	цаг	10ц	1	15.000	150.000
Нийт тооцоо						904.000

оОо

Эрүүл мэндийн газрын даргын оны
 дугаар сарын ны өдрийн
 А.А. дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**“Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд зохион байгуулах
 бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын
 сургалтын хөтөлбөр**

2022 оны 09 сарын 08, 09 /Танхимын сургалт/		
Хугацаа	Сургалтын сэдэв	Сургалт заах багшийн нэр, Албан тушаал
Сургалтын 1 дэхь өдөр		
10.00-10.05	Сургалтын бүртгэл	А.Ууганцэцэг /НЭМТ-ийн мэргэжилтэн/
10.10-10.20	Сургалтын нээлт	Д.Балжмаа /НЭМТ-ийн дарга/
10.20-10.30	Сургалтын танилцуулга, сургалтын өмнөх сонжуур	Ц.Амарсайнуу /НЭМТ-ийн мэргэжилтэн/
10.30-11.10	Хөдөлгөөний тухай ойлголт сургалт	Ц.Амарсайнуу /НЭМТ-ийн мэргэжилтэн/
11.10-11.20	Цайны завсарлага	
11.20-12.10	Стресс менежмент	Жаргалтай амьдрал төвийн сэтгэл зүйч
12.10-13.00	Агаарын бохирдол ба эрүүл мэнд сургалт	Б.Бямбатогтох /ХШҮМХ-ийн мэргэжилтэн /
13.00-14.00	Үдийн завсарлага	
14.00-16.00	Ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнийг зааж чадавхжуулах	Д. Дэжидмаа /Монгол улсын шинжээч, хийн дасгалын үндэсний сургагч багш, биеийн тамир магадлан итгэмжлэлийн улсын шилдэг арга зүйч Аэробек, айзамт гимнастикийн багш дасгалжуулагч, нийтийн цэнгээнт бүжгийн багш, дасгалжуулагч/
16.00-16.15	Цайны завсарлага	
16.15-17.00	Ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнийг зааж чадавхжуулах /Үргэлжлэл/	Д. Дэжидмаа /Монгол улсын шинжээч, хийн дасгалын үндэсний сургагч багш, биеийн тамир магадлан итгэмжлэлийн улсын шилдэг арга зүйч Аэробек, айзамт гимнастикийн багш дасгалжуулагч, нийтийн цэнгээнт бүжгийн багш, дасгалжуулагч/
Сургалтын 2 дахь өдөр		
10.00-10.05	Сургалтын бүртгэл	А.Ууганцэцэг /НЭМТ-ийн мэргэжилтэн/
10.05-16.00	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авахад чадавхжуулах	Д. Дэжидмаа /Монгол улсын шинжээч, хийн дасгалын үндэсний сургагч багш, биеийн тамир магадлан итгэмжлэлийн улсын шилдэг арга зүйч Аэробек, айзамт гимнастикийн багш дасгалжуулагч, нийтийн цэнгээнт бүжгийн багш, дасгалжуулагч/
11.00-11.15	Цайны завсарлага	
11.15-13.00	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин	Д. Дэжидмаа /Монгол улсын шинжээч, хийн дасгалын үндэсний сургагч багш,

	тогтоох сорил авахад чадавхжуулах /Үргэлжлэл/	биеийн тамир магадлан итгэмжлэлийн улсын шилдэг арга зүйч Аэробек, айзамт гимнастикийн багш дасгалжуулагч, нийтийн цэнгээнт бүжгийн багш, дасгалжуулагч/
13.00-14.00	Үдийн завсарлага	
14.00-16.00	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авахад чадавхжуулах /Үргэлжлэл/	Д. Дэжидмаа /Монгол улсын шинжээч, хийн дасгалын үндэсний сургагч багш, биеийн тамир магадлан итгэмжлэлийн улсын шилдэг арга зүйч Аэробек, айзамт гимнастикийн багш дасгалжуулагч, нийтийн цэнгээнт бүжгийн багш, дасгалжуулагч/
16.00-16.10	Цайны завсарлага	
16.10-17.00	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авахад чадавхжуулах /Үргэлжлэл/	Д. Дэжидмаа /Монгол улсын шинжээч, хийн дасгалын үндэсний сургагч багш, биеийн тамир магадлан итгэмжлэлийн улсын шилдэг арга зүйч Аэробек, айзамт гимнастикийн багш дасгалжуулагч, нийтийн цэнгээнт бүжгийн багш, дасгалжуулагч/
17.00-17.10	Сургалтын сонжуур	дараах Ц.Амарсайнуу /НЭМТ-ийн мэргэжилтэн

----- о О о -----